

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ХАМРАЛТ ОРЛОГО ШИМТГЭЛИЙН ӨР ХАРИУЦСАН БАЙЦААГЧ
ГАНБОЛДЫН ГАНЦЭЦЭГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт”							
Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах							
1	Арга хэмжээ 1.1.1 Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/ болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах,	Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2024 онд ирүүлсэн 15 чиглэл, 14 зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна.	Нийгмийн даатгалын мэдээллийн шинэ систем нэвтэрч, хөгжүүлэлт хийж байгаагаар холбогдуулан https://portal.ndaatgal.mn/ ажил олгогчийн мэдээллийг шинэчлэх, нэвтрэх эрхийн мэдээллийг оруулах, шимтгэлийн тайлан илгээх заавар, мэргэжил арга зүйн зөвлөгөөг холбогдох санхүүгийн ажилтан, удирдлагад тухай бүр чиглэл өгч ажилласан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/199 дугаар тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам, Хөдөлмөр. Нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны А/44, А/43 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл	2025-01-02 2025-06-30	

					төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрлийн код"-ыг ажил олгогчдод танилцуулан тушаалыг хэрэгжилтийг ханган ажилласан.		
2	Арга хэмжээ 1.1.2 Ажил олгогч, иргэд, даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, үр дүнг хагас жил тутам Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх,	2 удаагийн сэтгэл ханамжийн судалгаа хийгдсэн байна.	2024 онд ажил олгогч, иргэд, даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгааг цахим хэлбэрээр QR код таниулан авч, нэгтгэсэн.	Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн сэтгэл ханамжийг 1-5 оноогоор дүгнэж, судалгааны үр дүнг албан бичгээр 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын ерөнхий газар хүргүүлсэн байна.	2025 оны эхний хагас жилийн байдлаар ажил олгогч, иргэд, даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгааг цахим хэлбэрээр QR код таниулан авч, судалгааны нэгтгэлийг урьдчилсан байдлаар гаргасан.	2025-01-02 2025-06-30	

Зорилт 2. "Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт"

Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах

1	Арга хэмжээ 2.1.1 Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувийг хангаж ажиллана.	2024 онд 97 ажил олгогч, 569 даатгуулагчийг албан журмын даатгалд хамруулав.	Ажил олгогчийн тоог 98, даатгуулагчийн тоог 700 болгон нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна.	Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын санд 64,324.41 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.	2025-01-02 2025-06-30	
2	Арга хэмжээ 2.1.2 Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний үлдэгдэлээс 30-аас доошгүй хувиар бууруулах,	Хуримтлагдсан авлагыг тухайн санхүүгийн жилд бүрэн барагдуулсан байна.	Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын хэмжээ 2024 оны жилийн эцэст 11,960.18 сая төгрөгт хүрсэн.	-Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын хэмжээ 3,588.05 сая төгрөгийг /2.1.4-д зааснаас бусад	2025 оны 1 дүгээр сарын авлага 11,960.18 сая төгрөг, эхний хагас жилийн байдлаар 11,840.23 төгрөг болж 1.2 хувиар буурсан байна. Авлага барагдуулах ажлын хүрээнд: Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/38 тушаалаар салбарын	2025-01-02 2025-06-30	

				шимтгэлийн авлага/ бүрэн барагдуулах. - Шинээр нэмж өр авлага үүсгэхгүй байх тал дээр анхаарч ажиллах.	хэмжээнд 2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах” жил болгон зарласантай холбогдуулан өр, авлага барагдуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/199 тушаал баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын 6-д заасан Шимтгэлийн өр барагдуулахаар орлого шимтгэлийн байцаагч тус бүр аж ахуйн нэгж байгууллагуудад авлага барагдуулах чиглэлээр өр, авлага үүссэн хугацаа, авлагын насжилт их хэмжээний өртэй, ажил олгогчийн удирдлагатай уулзалт хийж, шат дараалсан арга хэмжээ авч ажиллалаа. ❖ Албан шаардлага: 1,047.20 сая төгрөгийн 56 ажил олгогч нарт урсгал авлага үүсгэсэн, сар дамнуулан шимтгэлээ төлдөг байгууллагуудын удирдлагуудад урсгал авлага үүсгэхгүй байхад анхааруулж, албан шаардлага хүргүүлж ажилласан. ❖ Уулзалт, гэрээ: 1,891,088.09 сая төгрөгийн өглөгтэй 11 ажил олгогчтой уулзалт хийж, авлага барагдуулах гэрээ байгуулан газрын даргаар батлуулан ажилласан. Ажил олгогч нар тухай бүр шимтгэлээ заасан хугацаанд төлж, 563.92 сая төгрөгийн авлага барагдсан байна. Цаашид гэрээний хугацаанд шимтгэлээ төлж барагдуулах, гэрээ зөрчсөн		
--	--	--	--	--	---	--	--

					тохиолдолд дараагийн шат дараалсан арга хэмжээ авч ажиллахыг мэдэгдсэн. ❖ Данс хаах: Албан шаардлага болон гэрээний дагуу шимтгэл төлөгдөөгүй 2,219.33 сая төгрөгийн өглөгтэй 81 ажил олгогчийн харилцах дансны гүйлгээг түр зогсоосон. ❖ Шүүхэд нэхэмжилсэн: Авлага барагдуулах ажлын хүрээнд 2025 оны эхний хагас жилийн хугацаанд 881.67 сая төгрөгийн өртэй 13 ажил олгогчоос: ✓ Шүүхийн шийдвэр албадан биелүүлэх-1 ✓ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа зогссон-1 ✓ Эрэн сурвалжлахад өгсөн-6 ✓ Ажиллагаанд байгаа-2		
3	Арга хэмжээ 2.1.3 Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулсан байх,	Шимтгэлийн өргүй гарсан байх.	Төсөвт байгууллагын шимтгэлийн өр 48.18 сая төгрөг, орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өр 4.09 сая төгрөг байна.	Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулж шинээр нэмж өр үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах.	2025 оны эхний хагас жилийн байдлаар Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулж шинээр нэмж өр үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах.	2025-01-02 2025-06-30	
4	Арга хэмжээ 2.1.4 Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх ажил зохион байгуулах,	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн дагуу орлогын гүйцэтгэл 100 % хангуулна.	Нийгмийн даатгалын санд 101,508.52 сая төгрөгийн орлого хуримтлуулав.	Нийгмийн даатгалын санд 105,086.70 сая төгрөгийн орлого төвлөрүүлнэ.	2025 оны эхний хагас жилийн байдлаар нийгмийн даатгалын санд 47,198.87 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлэхээс 1174 ажил олгогч 8594 даатгуулагчийн 64,324.43 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 165 хувиар биелүүлэв.	2025-01-02 2025-06-30	

Зорилт 3. “Төрийн үйлчилгээний чанар хөгтээмжийг сайжруулах зорилт”

Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах

1	Арга хэмжээ 3.1.1 Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, шийдвэр, тайлан, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх,	- 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна. -Арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн	2024 онд тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, биелэлтийг нэгтгэн авч, дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 89,4%-тай хэрэгжсэн байна.	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангагдсан байна.	Дээд газраас ирсэн тогтоол, шийдвэр, албан даалгаврын биелэлт, E-DOC программаар ирсэн 10 албан бичгүүдийг хугацаанаас нь өмнө тогтмол шийдвэрлэх, шимтгэлийн өглөг, авлагын насжилтийн судалгааг тухай бүр гаргаж, холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.	2025-01-02 2025-06-30	
2	Арга хэмжээ 3.1.2 Байгууллага, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах,	-Улирал бүрийн 20-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлнэ. -Өргөдөл шийдвэрлэлтийг 100% хугацаанд нь, үнэн зөв, бодит үр дүнтэй шийдвэрлэсэн байна.	Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн түвшин салбарын хэмжээнд 2024 онд 100%-тай хэрэгжсэн байна.	Иргэд, даатгуулагч, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, шийдвэрлэлтийн мэдээг үнэн зөв гаргаж, хүргүүлсэн байна.	2025 оны хагас жилийн байдлаар нийт 12 ажил олгогчоос ирүүлсэн албан тоотыг үндэслэн цалин залруулга, даатгуулагчийн төрөл код солихыг холбогдох хууль, журам, анхан шатны нотлох баримт зэргийг үндэслэн тухай бүр хугацаанд нь шийдвэрлэсэн.	2025-01-02 2025-06-30	
3	Арга хэмжээ 3.1.3 Дээд байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр нь хүргүүлж ажиллах,	-Хугацаанд нь хүргүүлэх, -Баримтын чанар, үзүүлэлт тодорхой байна.	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь ирүүлсэн байдал 75%-тай байсан.	Үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/38 тушаалаар салбарын хэмжээнд 2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах” жил болгон зарласантай холбогдуулан ажил олгогч нарын шимтгэлийн өрийн насжилтын судалгаа, биелэлтийг тухай бүр гарган холбогдох дээд байгууллагад хүргүүлэн ажилласан.	2025-01-02 2025-06-30	

Зорилт 4. “Хүний нөөцийг шилж бүрдүүлэх, чадавхижуулах зорилт.”

1	Арга хэмжээ 4.1.1 Ажил олгогч, даатгуулагч, иргэдийн нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах,	-Даатгуулагчид чиглэсэн сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах, - 30-аас доошгүй аж ахуйн нэгжийг хамруулах, -Иргэд, даатгуулагчдын 10-иас доошгүй хувийг хамруулсан байна.	Ажил олгогч, иргэд, даатгуулагчид чиглэсэн 8 удаагийн сургалтад 9 аж ахуйн нэгжийн 3276 иргэд, даатгуулагч, ажил олгогчийг хамруулсан.	Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг дээшлүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулж, иргэд даатгуулагчийг өргөнөөр хамруулсан байна.	2024 оноос эхлэн салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системийг үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэнтэй холбоотойгоор цаашид ажил олгогчдын шимтгэл төлөлтийн тайланг SICOS программаар хүлээн авахад анхаарах асуудал, даатгуулагчдын ажил мэргэжлийн ангилал, төрлийн кодыг хүний нөөцийн программтай тулгах, даатгуулагчийн регистер буруу оруулах, цалин засах зэрэг зөрчил гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллах тухай аж ахуй нэгж байгууллагад тогтмол мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. 2025 оны сүүлийн хагас жилийн байдлаар ажил олгогч, даатгуулагч нарт зориулсан сургалт хийх хуваарьтай байна.	2025-01-02 2025-06-30	
2	Арга хэмжээ 4.1.2 Нийгмийн даатгалын байгууллагад хэрэгжүүлж буй ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг ханган ажиллах,	Шинээр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулна.	Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний болон ажлын байрны стандартыг мөрдөж ажилласан.	Ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулж, үр дүнд хүрсэн байна.	Ажлын байрны болон хэлтсийн хамт олны уур амьсгалыг сайжруулах зорилгын хүрээнд "Талархал ба Сэтгэлийн шивнээ үг" аянг зохион 2025 оны 3 дугаар улиралд зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.	2025-01-02 2025-06-30	
3	Арга хэмжээ 4.1.3 Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах,	Дуудлага алдалт 10%-аас хэтрүүлэхгүй ажилласан байна.	Ирсэн дуудлага 20620, дуудлага алдалт дунджаар 47%.	Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч, ажилласан байна.	2025 оны эхний хагас жилийн байдлаар хуваарийн дагуу ажил олгогч, даатгуулагчдад утсаар (CallPro) албан тушаалын тодорхойлолтонд заасан чиглэлийн дагуу мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.	2025-01-02 2025-06-30	
4	Арга хэмжээ 4.1.4 Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгааг - "Рийл" улиралд 3-аас доошгүй удаа;	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчилсан	Хэлтсийн төлөвлөгөөт хуваарийн дагуу Газрын пэйж хуудсаар дамжуулан Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчилсан сурталчилгаа бэлтгэж түгээх, Нийгмийн даатгалын ерөнхий	2025-01-02 2025-06-30	

	сурталчлах, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангах,	- "Постер" сард 3-аас доошгүй удаа; - "Видео контент" улиралд 1 удаа; Хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан мэдээ мэдээлэл өгөх, сард 2-оос доошгүй удаа.	мэдээллийн хэрэгслээр сурталчлаж, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангаж ажилласан.	сурталчилгаа бэлтгэж түгээх. Нийгмийн даатгалын ерөнхий газрын пэйж хуудсаар нийтэлсэн мэдээ мэдээллийг тогтмол түгээж ажилласан байна.	газрын пэйж хуудсаар нийтэлсэн мэдээ мэдээллийг тогтмол түгээж ажилласан.		
5	Арга хэмжээ 4.1.5 Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх,	Ажил олгогчийн НДШ-ийн тайланд ирүүлэх даатгуулагчийн мэдээллийг бүрэн, зөв бүрдүүлсэн байх	Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан.	- Даатгуулагчийн үндсэн мэдээллийг бүрэн, зөв хүлээн авсан байна. - Даатгуулагчийн төрлийг бүрэн, зөв хүлээн авсан байна. - Даатгуулагчийн улсын кодыг бүрэн, зөв хүлээн авсан байна. - Даатгуулагчийн ажил мэргэжлийн ангиллыг бүрэн, зөв хүлээн авсан байна.	2025 оны 01-05 дугаар сарын ажил олгогчийн шимтгэлийн тайланг цахимаар болон цаасаар хүлээн авч баталгаажуулсан. ✓ 1 дүгээр сард нийт идэвхитэй 811 ажил олгогчийн 11,993.98 сая төгрөг ✓ 2 дугаар сард нийт идэвхитэй 808 ажил олгогчийн 12,528.13 сая төгрөг ✓ 3 дугаар сард нийт идэвхитэй 807 ажил олгогчийн 13,265.58 сая төгрөг ✓ 4 дүгээр сард нийт идэвхитэй 801 ажил олгогчийн 13,298.41 сая төгрөг ✓ 5 дугаар сард нийт идэвхитэй 752 ажил олгогчийн 13,651.43 сая төгрөг	2025-01-02 2025-06-30 2025-01-02 2025-06-30	
6	Арга хэмжээ 4.1.6 Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах,	Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангах	Программ хангамжуудын эрхийн тохиргоог зөв хийх, байцаагч ажилтнууд программ хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажилласан.	Программ хангамжуудын эрхийн тохиргоог зөв хийх, байцаагч ажилтнууд программ хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.	Нийгмийн даатгалын https://sicos.ndaatgal.mn/ , UB ERP, E-DOC программын өөрийн бүртгэлтэй нэвтрэх эрхийн бүртгэлийн тохиргоог зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг бүрэн хангаж ажилласан.	2025-01-02 2025-06-30	
		МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу,	МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан	МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан	МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу,	2025-01-02 2025-06-30	

		судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх	бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн хэрэгжүүлж, ажилласан.	бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна.	судалгааг цаг хугацаанд нь тухай бүр хүргүүлэн ажилласан.		
--	--	--	---	--	---	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Арга хэмжээ 1. Үндэсний бичгийн танхимын сургалтанд хамрагдан, бие даан хичээллэж, үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болох,	Танхимын сургалтад 90%-иас дээш ирцтэй хамрагдсан байна. -Албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болсон байна.	Үндэсний бичгийн цахим сургалтанд бие даан хамрагдаж, анхан шатны түвшингийн мэдлэгтэй болсон.	Зохион байгуулагдсан хугацаанд	2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжиж байгаатай холбогдуулан Газрын албан хаагчид Нийслэлийн 50 дугаар сургуулийн монгол хэл, бичгийн багш Ц.Энхболорын сургалтанд хамрагдсан.	2025-01-02 2025-06-30	
2	Арга хэмжээ 2. Нийгмийн даатгалын байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнд хамрагдах,	Сургалт, зөвлөгөөнд бүрэн хамрагдсан байна.	Нийгмийн даатгалын байгууллага болон холбогдох газрын сургалтанд хамрагдсан.	Зохион байгуулагдсан хугацаанд	✓2025.03.21-ны 18:00 цагт ZOOM аппликэйшнээр НДЕГ-ын дарга Б.Батжаргал салбарын хэмжээнд 2024 оны санхүүгийн тайлангийн явцтай танилцаж, тайлан гаргахтай холбоотой тулгамдаж буй асуудлын тухай ярилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтанд албан хаагчдын хамт оролцсон. ✓2025.04.10-ны өдөр 13:30 цагт Дүүргийн Засаг Даргын Тамгын газраас Монгол улсын "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль", "Зөрчлийн тухай хууль", "Замын хөдөлгөөний дүрэм" болон "Е-Police" аппликейшн ашиглах болон	2025-01-02 2025-06-30	

					зөрчил ирүүлэх заавар, зөвлөмж танилцуулах сургалтанд Нийслэлийн Онцгой байдлын газрын хурлын танхимд хамрагдсан. ✓ 2025.05.13-ны өдөр 14:00 цагт Улсын Ерөнхий Прокурорын газраас зохион байгуулсан "Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан"-г улсын хэмжээнд нэвтрүүлэх сургалтанд Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар болон 9 дүүргийн албан хаагчид хамрагдах сургалтанд хамрагдсан. ✓ 2025.05.28-29-ний өдрүүдэд 08:00-19:00 цагт Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлөөс "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал", "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" Нийслэлийн зөвлөгөөнд Соёлын төв өргөөний танхимд хамрагдсан. ✓ 2025.06.06-ны 11:00 цагт ZOOM аппликэйшнээр НДЕГ-ын сургалтанд оролцсон.		
3	Арга хэмжээ 3. Гадаад хэл, мэдээлэл технологи, ажлын онцлогоос хамааран ур чадвараа дээшлүүлэх,	Өөрийн мэдлэг чадварын түвшингээ тодорхойлж, хувь хүний гадаад хэлний түвшин, мэдээлэл технологийн чадвараа ахиулах сургалтад хамрагдана.	Мэдээлэл технологийн түвшингээ ахиулах зорилгоор EXCEL программын дунд шатны цахим сургалтанд хамрагдаж, өөрийгөө хөгжүүлсэн.	Тухай бүр	2025 оны сүүлийн хагас жилд гадаад хэлний мэдлэгийн түвшингээ тогтоож, түвшин ахиулах сургалтанд хамрагдана.	2025-01-02 2025-06-30	

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХАМРАЛТ, ОРЛОГО, ШИМТГЭЛИЙН
ӨР ХАРИУЦСАН БАЙЦААГЧ

...../Г.ГАНЦЭЦЭГ/

2025 06. 30.
.....